

## СЭТГҮҮЛИЙН ДИЗАЙНЫ ОНЦЛОГ

М. Наранмандах\*

\* “Соёл-Эрдэм” дээд сургуулийн Мэргэжлийн тэнхимийн эрхлэгч, магистр, докторант

**Түлхүүр үг:** сэтгүүлийн дизайны тулгуур элементүүд, гарчиг, багана, шрифт, гэрэл зураг, өнгөний зохицол, сэтгүүлийн дизайны өвөрмөц тал, дизайны зарчмууд

Аливаа сэтгүүл зах зээл дээр оршин тогтнох, эс оршин тогтнохын нууц нь түүний мэдээллийн багтаамжид бус, харин гадаад харагдах байдал болох дизайнаас ихээхэн шалтгаалдаг. Тиймээс сэтгүүлийн хувьд сайн дизайн маш чухал. Сониныг уншигчид гарчиглаад худалдан авахаа шийддэг бол сэтгүүлийг гоёмсог байдал, өнгөний зохицол, мэргэжлийн өндөр төвшний гэрэл зураг зэрэг шийдлээс нь хамаарч худалдан авахаа шийддэг.

Сэтгүүл зүй судлаач М. Зулькафилийн тодорхойлсноор: “Дизайн гэдэг бол бодит хэрэглээнд зориулагдсан өөрийн гэсэн мөн чанар бүхий өвөрмөц хэв маяг, хэлбэрийг нэгтгэсэн нөхцөл орчин юм”<sup>1</sup>. Сэтгүүл нь сониныг бодвол цаг хугацаа, орон зайны багтаамж илүү, танин мэдүүлэх, зугаацуулан цэнгүүлэх, гэгээрүүлэх мэдээлэл түлхүү ордог онцлогоосоо хамаарч өөрийн гэсэн дизайны өвөрмөц шийдэл, хэв загварыг шаарддаг мэдээллийн хэрэгсэл билээ. Сэтгүүлийн дизайнд сонин хэвлэлийн дизайн шиг текст, гэрэл зураг, шрифт, агаар, өнгөний хоорондын зохицол чухал хэдий ч өөрийн гэсэн онцлог ялгаатай байдаг. Ерөнхийдөө сэтгүүлийн нийтлэлийн

бодлого, чиглэлээс хамаарч дизайн тодорхойлогддог. Сэтгүүлийн дизайны хамгийн шилдэг уламжлал нь олон тооны фото зурагтай, гялгар цаасан дээр хэвлэгдэх юм. Сэтгүүл ямар ч төрлийн хэлбэртэй байж болно. “Өнөөдөр сэтгүүл нь олон янз хэлбэрийн дүр төрх бүхий дизайны ертөнц, олон нийтийн соёл, сэтгэхүйн томоохон хэрэгсэл, бизнес болжээ. Тиймээс сэтгүүлийн дизайны тухай түгээмэл ерөнхий тодорхойлолт, бүхнийг нэгтгэсэн зарчим гэж үгүй ажээ. Өөрөөр хэлбэл сэтгүүл бүрд өөрийн дизайн байна гэсэн үг”<sup>2</sup> доктор Б. Болд-Эрдэнэ бичсэн байдаг. Гэсэн хэдий ч сэтгүүлийн дизайнд баримтлах ерөнхий тулгуур элементүүд, тэдгээрт баримтлах ерөнхий зарчим гэж бий. Үүнд гарчиг, багана, шрифт, гэрэл зураг, өнгөний зохицол багтана.

**Гарчиг:** сэтгүүлийн аливаа мэдээллийн гарчиг нь мэдээлэх, чимэглэх хоёр үндсэн үүргийг гүйцэтгэдэг. Сайн гарчиг оноож өгч чадна гэдэг тухайн материалд төдийгүй, сэтгүүлийн худалдан авалтанд онцгой үүрэгтэй. Энэ нь сонирхолтой сайхан гарчиг нь материалаа “худалдана” гэсэн үг юм. Гэхдээ сайн гарчиг өгч байна гээд мэдээллээ бүрэн задалж болохгүй. Учир нь уншигч “За энэ ойлгомжтой боллоо” гээд уншихгүй орхих магадлалтай. Мөн гарчиг нь зохиогчийн өөрийн сэтгэгдэл, үзэл бодол байж болохгүй гэсэн сэтгүүл зүйн ерөнхий



зарчимд захирагдсан байх ёстой. Гарчгийн чимэглэх үүргийн хувьд сэтгүүлийн дизайнд баримтлах хэд хэдэн зарчим бий. Үүнд “сэтгүүлийн эх бэлтгэл хийхдээ хамгийн эхлээд гарчгаа тавиад дараа нь зургаа байрлуулсны хойно текстээ өрөх ёстой”<sup>3</sup> гэсэн зарчим юм. Дизайнтайгаа холбон томоохон материалыг уншигчид хүлээн авахад хялбар болгох болон зарим хэсгийг тодруулах зорилгоор хэд хэдэн хэсэгт жижиглэн хувааж дэд гарчгийг сайн ашиглавал үр дүнтэй. Түүнчлэн сонины дизайны нэгэн адилаар материалын хамгийн чухал, сонирхолтой хэсгийг цонхлох зэргээр уншигчдын анхаарлыг татаж болох юм. Ингэхдээ уншигчдынхаа төвшинд тохируулж материлынхаа хэмжээг тааруул гэсэн зарчимд захирагдах ёстой.

Гарчгийг рекламны доор байрлуулж огт болохгүй. Хэрвээ таны материалын гарчиг рекламны доор байрласан бол таны мэдээллийн үнэ цэнэ, дизайны шийдэл ямар ч үр ашиггүй болно гэдгийг байнга санах хэрэгтэй. Мөн нэг гарчгийг нөгөө гарчгийн хажууд бүү тавихаас аль болох зайлсхийх нь зөв. Материалууд агуулгын хувьд холбоотой биш л бол зэрэгцүүлж тавьж болохгүй. Үүгээрээ сонины гарчгийн дизайнаас эрс ялгаатай юм. Гарчгуудыг зэрэгцүүлж тавьснаас уншигчид мэдээллийн аль нэгийг уншихгүй орхих, нэг нь нөгөөтэй холбоотой мэт сэтгэгдэл төрүүлж төөрөгдөлд оруулах сөрөг талтай байдаг. Тиймээс сэтгүүлийн дизайнд гарчгийг зэрэгцүүлж тавихыг хориглодог.

**Багана:** сэтгүүлд баганыг өндөр байснаас өргөн байсан нь дээр гэж үздэг. Учир нь олон багана байх нь сэтгүүлийн хувьд зохимжгүй, уншихад хүндрэлтэй төдийгүй уншигчдын анхаарлыг сарниулах сул талтай. Сэтгүүлийн дизайны гол зорилго нь уншигчдад мэдээллийг хүлээн авах хамгийн амар, хялбар шийдлийг олох явдал билээ. Тиймээс олон нарийн баганад мэдээллийг хувааж тавихыг

чухалчилдаггүй. Мөн “нэг хуудасны сүүлийн багана дуусахад үргэлжлэлийг уншигчид амархан олдог байх хэрэгтэй. Аль болох нэг материалыг өөр хуудас дээр шилжүүлж бүү тавь. Энэ нь уншигчдын сонирхлыг бууруулдаг”<sup>4</sup>. Учир нь сэтгүүл нь сониныг бодвол хуудасны тоо харьцангуй олон байдаг.

**Э**хлэл байхгүй, төгсгөл ч байхгүй материал хэвлэх нь манай сэтгүүлүүдэд түгээмэл ажиглагдаж байна. Ялангуяа уран зохиолын томоохон бүтээлийг хэд хэдэн дугаар дамнуулан тавьдаг. Тухайлбал: “TV ZONE” сэтгүүл 2010 оны 10-р сараас эхлэн А.Дюмагийн “Монте Кристо гүн” зохиолыг нэг дугаартаа нэг нүүрээр тавьсан байна. Энэ нь долоо хоног бүр уншигч тухайн зохиолоос нэг хуудсыг л унших боломжтой бөгөөд уг зохиолыг дуусгахын тулд уншигч бүтэн жилийн турш долоо хоног бүр үргэлжлүүлэн унших шаардлагатай болж байгаа нь оновчгүй сонголт болжээ. Эхлэл болон төгсгөл байхгүй ямар ч материал уншигчдын анхаарлыг татаж чадахгүйг анхаарах хэрэгтэй.

**Шрифт:** шрифт гэдэг үг нь schriff буюу захиа гэсэн герман үгээс гаралтай. “Сонин хэвлэлийн дизайны гол асуудлын нэг нь шрифтыг оновчтой зөв сонгох асуудал бөгөөд уншигчдад хялбар уншигдахгүй л бол сайн шрифтэд тооцогдохгүй ч зарим тохиолдолд нарийн, ур хийцтэй, чамин шрифт хэрэглэхийг үгүйсгэхгүй”<sup>5</sup>. Тиймээс сэтгүүлийн хамгийн хэцүү төвөгтэй ба нууцлаг элементүүдийн нэг нь шрифт юм. “Зарим шрифтүүд бараг бүх бичлэгийн төрөл зүйл, нийтлэл материалд тохирч байдаг бол зарим нь тэр бүр тохирдоггүй. Шрифт бүр өөр өөрийн онцлог шинж чанартай... Шрифтын сонголт олон болохын хэрээр дизайнер хүн тухайн материал нийтлэлд зохицуулан, шрифтээ сонгох нь амаргүй байдаг. Дэлхийн жишгээр шрифтыг хоёр зориулалтаар хэрэглэдэг.

1. Эх бичвэрт хэрэглэгддэг шрифтүүд.



2. Сонины толгой буюу гарчигт хэрэглэгддэг шрифтууд.

Гэтэл манай сонинууд эх бичвэрийн шрифт, гарчиг болон толгойн шрифтыг ялгаж салгаж хэрэглэхгүй байгаа нь түгээмэл ажиглагддаг<sup>6</sup>. Шрифтын сонголт, ач холбогдол дээр бага анхаарал тавьдагаас дээрх алдаа үүдэн гардаг. Гэсэн хэдий ч шрифтын сонголт хийхдээ анхаарах зүйлсийн талаар мэдлэгтэй болох нь энэхүү алдаанаас сэргийлэх гол арга зам юм. Сэтгүүлд шрифтыг сонгохдоо нэг нүүрэн дээр олон янзын шрифт хэрэглэхгүй байхыг чухалчлах хэрэгтэй. Хэтэрхий хэлбэр, загвар, гоёмсог байдал хөөх нь унших явцыг хүндрүүлдэг. Гэсэн ч нөгөө талаасаа шрифтыг уншигчдын анхаарлыг татахаар өргөн ашигла гэсэн зарчим сэтгүүлд үйлчилдэг. Ер нь шрифттээ хэрхэн зөв сонгосноос уншигдах, уншигч-

дад хүрэх нь ялгаатай байна. Хуучин, шинэ шрифтээр материалыг бичихэд уншигчдын хүлээн авах байдал огт өөр байна. Тухайлбал, хуучин шрифтээр ихэвчлэн эртний ном хэвлэл бичигдсэн байдаг бөгөөд эдгээр шрифт нь уншихад төвөгтэй байхаас гадна эртний, хуучирсан гэх мэдээлэл, сэтгэгдлийг уншигчдад төрүүлэх талтай. Өөрөөр хэлбэл, хуучны сонирхолгүй зүйл гэсэн мэдээллийг шрифт маань өөрөө уншигчид өгнө. Тиймээс шрифтын сонголт маш чухал юм.

**Гэрэл зураг:** гэрэл зураг нь уншигчдыг сэтгүүл худалдан авахад нөлөөлдөг нэмэлт хэмжүүр болдог тухай өмнө нь дурдсан билээ. Учир нь уншигчид

сэтгүүлийг уншихаас илүү харж мэдээлэл авдаг. Тиймээс гэрэл зурагт нэмэлт мэдээлэл дамжуулах ёстой гэсэн зарчмаар хандах ёстой. Тухайн үйл явдлын талаар ч юм уу, тухайн материалын сэдэвт тохирох зураг байгаа гэсэн санамсаргүй сонголтоос аль болох татгалзах нь гэрэл зургийн үнэ цэнэ, ач холбогдлыг өргөж, худалдан авалтанд шууд нөлөөлдөг. Зураг сонирхолтой байхаас бус тэнэглэл, гайхаж эргэлзэхээр байх ёсгүй. Гэрэл зураг нь тухайн материалд

«

*Сэтгүүлийн дизайнд сонин хэвлэлийн дизайн шиг текст, гэрэл зураг, шрифт, агаар, өнгөний хоорондын зохицол чухал хэдий ч өөрийн гэсэн онцлог ялгаатай байдаг. Ерөнхийдөө сэтгүүлийн нийтлэлийн бодлого, чиглэлээс хамаарч дизайн тодорхойлогддог. Сэтгүүлийн дизайны хамгийн шилдэг уламжлал нь олон тооны фото зурагтай, гялгар цаасан дээр хэвлэгдэх юм.*

»

нэмэлт мэдээлэл л болж чадахгүй бол тэр гэрэл зургийг заавал ашиглах шаардлагагүй. Гэрэл зурагт тухайн материалыг баримтжуулахаас гадна агуулгын хувьд улам баяжуулж, сонирхолтой, анхаарал татахуйц байх нь хамгийн чухал шалгуур юм.

Хэм хэмжээг тохируулах нь ихээхэн ач холбогдолтой. Олон хуудас дараалсан том гэрэл зураг байвал уншигчаа бичиг үсэг мэддэггүй гэж үзсэн мэт эгдүүцэл төрүүлэх талтай. Бичвэр бол муу, зураг бол сайн гэж бүү явцуурч болохгүй. Гэхдээ сонирхолтой сайхан гэрэл зураг харсан хүн найз нөхөд, ажлынхан болон гэрийнхэндээ ярина, үзүүлнэ. Гэрэл зураг нь тухайн мэдээллийг ойлгоход тус дөхөм болдог. Улс төрийн тухай томоохон шүүмжлэлт нийтлэлийг “томоохон хошин зураг” дагах хэрэгтэй гэх мэт.

Гэрэл зурган дээр бичвэр бичих боломжийг сайн ашиглах хэрэгтэй. Энэ аргыг “Гоодаль” сэтгүүл маш сайн ашигладаг. Мөн шаардлагатай үед



зургийг хайчилж, тасалж тавихыг зөвлөдөг ч үүнийг чухалчлах хэрэггүй гэж үздэг. Түүнчлэн гэрэл зураг бүрийг тайлбартай байхыг анхаарах хэрэгтэй. Яагаад гэвэл уншигч тайлбаргүй зурагт дургүй байдаг. Тайлбарын агуулга нь уг гэрэл зургийг давтсан, нуршсан байх ёсгүйгээс гадна шрифт нь материалын шрифтээс жижиг, өргөн байх ёстой. Сэтгүүлд зөвхөн гэрэл зураг ашиглахаас гадна гар болон зураасан график зураг зэргийг өргөн ашиглахыг зөвлөдөг.

**Өнгөний зохицол:** ихэнх сэтгүүл өнгөт байдаг учраас сэтгүүлийн дизайнд өнгөний зохицлын асуудал үнэхээр чухал билээ. Үүнд хамгийн чухал нь үсэг, дэвсгэр өнгө (фон) хоёрын хоорондын зохицол юм. Учир нь "үсгийн өнгө, дэвсгэрийн өнгөнөөс хамаарч материалыг уншихад амар, эсвэл хүнд байх болно. Тухайлбал, төрөлхийн өнгө ялгадаггүй хүн (дальтоник)-д цайвар ногоон үсгийг цэнхэр дэвсгэр дээр хэвлэвэл тэр хүн уншиж чадахгүй. Эрчүүдэд зориулсан сэтгүүлд ягаан дэвсгэр дээр ногоон үсгээр бичиж болохгүй. Судалгаанаас харахад эрчүүд өнгө сайн ялгадаггүй нь нотлогдсон төдийгүй, тохироогүй өнгөтэй материалыг уншихаасаа уншигчид амархан няцдаг ажээ.

Хар цагаан өнгийг ч гэсэн бодолтой сонгох хэрэгтэй. Цагаан дэвсгэр дээр хараар бичихэд бусад өнгөнөөс 42% илүү хурдан уншигддаг байхад хар дэвсгэр дээр цагаанаар бичих нь уншихад хүндрэлтэй болохыг аль 1920 онд Старч хэмээх эрдэмтэн нотолжээ. Мөн Паттерсон, Тинкер нарын судалгаагаар хар дэвсгэр дээрх цагаан үсэг нь цагаан дэвсгэр дээрх хар үсгээс 10,5 хувиар удаан уншигддаг болохыг нотолсон байна. Тус судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 77,7% нь цагаан дэвсгэр дээрх хар үсгийг илүү уншигддаг хэмээн хүлээн зөвшөөрчээ<sup>7</sup>. Тиймээс сэтгүүлийн дизайнд энэхүү өнгөний зохицлыг зөв тооцож ашиглах хэрэгтэй.

Орчин үеийн Монголын сэтгүүлүүдийн дотроос дизайны хувьд хамгийн өвөрмөц шийдэл бүхий "Гоодаль" сэтгүүлийн 2010 оны 10 дугаар сарын №25 дугаарт судалгаа хийхэд нийт 200 нүүрээс зөвхөн хар цагааны хослол бүхий нүүр 46 байгаа нь өнгөний хувьд өвөрмөц шийдэл бөгөөд хар цагааны хослол чухал болохыг харуулж байна.

"Өнгөнд хүнд, хөнгөн гэсэн ойлголт байдаг. Өнгө хичнээн бараан байх тусам хүнд сэтгэгдэл төрүүлж, хичнээн цайвар шингэн байх тусам хөнгөн сэтгэгдэл төрүүлдэг. Сэтгүүлийн дизайны өнгө хүний сэтгэл зүйд янз бүрийн үзэл бодлыг төлөвшүүлэхэд нөлөөлдөг. Өнгө дулаан бүлээн, хүйтэн зэврүүн, сэргэлэн цовоо, дорой мохой, хөнгөн, хүнд сэтгэгдлийг төрүүлж, орон зайг өргөн цэлгэр, эсвэл явцуу давчуу болгон харагдуулдаг. Өнгөний хувирлын тухай хүний сэтгэл санаанд нөлөөлөх нөлөөллийн тухай асуудал бол өнгөний зохицолтой холбоо бүхий маш нарийн төвөгтэй асуудлын нэг юм"<sup>8</sup>. Улаан өнгө нь хөдөлгөөнтэй, идэвхтэй, шар өнгө нь танил дотно, дулаан найрсаг шинж илэрхийлсэн бол ногоон өнгө нь тайван, энгүүн, цэнхэр өнгө нь хүйтэн, орон зайн хязгааргүй, цэвэр гэсэн шинж тэмдгийг илэрхийлдэг. Өнгө сэтгүүлийн дизайнд холилдож орохдоо дээр дурдсан мөн чанараа хадгалсан хэвээр байдаг.

**С**этгүүлийн дизайнд тулгуур элементүүд болох текст, гэрэл зураг, шрифт, өнгөний зохицол амин чухал үүрэг гүйцэтгэдэг. Сэтгүүлийн дизайн сонин хэвлэлийн дизайн адил төсөөтэй хэдий ч өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой болохыг дээр дурдлаа. Сэтгүүлийн нийтлэлийн бодлого, чиглэлээс хамаарч дизайн нь тодорхойлогддог хэдий ч түүнд тавигдах зарчим, шаардлагыг зөв хангаснаар сэтгүүлийн дизайн нь өөрийн үүргээ сайн биелүүлэх боломжтой юм.

### Ишлэл

- <sup>1</sup> Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 142 дахь тал.
- <sup>2</sup> Болд-Эрдэнэ Б. 2004. Сонины дизайн. УБ., 106 дахь тал.
- <sup>3</sup> Фрост К. 2008. Дизайн газет и журналов. М., с. 96.
- <sup>4</sup> Там же, с. 101.
- <sup>5</sup> Дэлгэрмаа С. 2006. Шрифт буюу үсгийн фондын тухай // "Сэтгүүл зүй" МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, №06/268, 154 дэх тал.
- <sup>6</sup> Мөн тэнд, 158-159 дэх тал.
- <sup>7</sup> Фрост К. 2008. Дизайн газет и журналов. М., с. 110.
- <sup>8</sup> Эрдэнэцэцэг Т. 2007. Сонины дизайны гарын авлага. УБ., 50 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2004. Сонины дизайн. УБ.
2. Дамбажав И., Зундуй Л. 1989. Сонин гаргах урлаг. УБ.
3. Дэлгэрмаа С. 2006. Шрифт буюу үсгийн фондын тухай // "Сэтгүүл зүй" МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, №06/268.

4. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.

5. Зулькафиль М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.

6. Чойсамба Ч. 2006. Сонирхолтой сэтгүүл зүй. УБ.

7. Эрдэнэцэцэг Т. 2007. Сонины дизайны гарын авлага. УБ.

8. Маккей Дж. 2002. Всё о журналах. М.

9. Фрост К. 2008. Дизайн газет и журналов. М.

### Summary

Elements of support like the text, photograph, font and colour adaptation play important role for journal design. To compare a journal with the newspaper it has more capacity of term and space. It is the media depending on its features which include more cognitive, entertainment and enlighten information. Journal design is the same newspaper design. But it has its own specific distinction. Depending on publications policy and purpose of journal the design is determined differently. Although is a result of true requirement and principle journal design has a possibility to be come true at last.